

**Туйлын тодорхой байх зарчим ба  
Монгол Улсын Эрүүгийн хууль**

**The Principle of Certainty and  
Criminal Code of Mongolia**

Тогоогийн Золбоо

*Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)*

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн*

*Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,*

*Улаанбаатар хот, Монгол Улс.*

*zolboo@num.edu.mn*

Болормаагийн Аззаяа

*Монгол Улсын Их Сургуулийн*

*Хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан*

*Улаанбаатар хот, Монгол Улс.*

*Azzayabolorma917@gmail.com*



**[Товч утга]**

2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээг тодорхой тохиолдол буюу гадаад ертөнцөд бий болсон бодит үйлтэй харьцуулан эрх зүйн силлогизм хийх үед зарим төрлийн гэмт хэргийн хэм хэмжээний бүрэлдүүний томьёолол тодорхойгүй байх, хэм хэмжээнүүд өөр хоорондоо ижил утга агуулгатай байх гэх зэрэг янз бүрийн асуудал тулгарсаар байгаа билээ. Энэ нь Ардчилсан эрх зүйт төрийн үндсэн баталгаа болсон хууль ёсны зарчимд нийцэхгүй тул Эрүүгийн хуулийн зөрчилдөөнтэй зарим асуудлыг тодорхойлж, түүнийг засаж залруулах, даван туулах арга замыг эрэлхийлэхийг зорилоо. Хууль ёсны зарчим, хэм хэмжээний цогцыг бүрдүүлэгч гэмт хэргийн бүрэлдүүнд тулгуурлан Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээ, түүнийг бүрдүүлж буй нэр томьёонд дүн шинжилгээ хийсэн ба үүний үр дүнд Эрүүгийн хуульд хэм хэмжээний цогцыг тодорхой бус байдлаар хуульчилж, хэм хэмжээ хоорондын уялдаа холбоог алдагдуулсан байна гэдгийг тодорхойлсон. Цаашлаад эрүүгийн хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн “хэм хэмжээг бүтээж, томьёолох арга зүйг” тодорхойлон, санал дэвшүүлсэн болно.

**[Түлхүүр үг]**

Эрүүгийн эрх зүй, гэмт хэргийн бүрэлдүүн, хэм хэмжээ, нэр томьёо, эрүүгийн хуулийн тодорхой бус байдал.

## **I. Оршил**

Ардчилсан эрх зүйт төрийн баталгаа болсон хууль ёсны зарчим нь ял заншлын эрх зүйд үндэслэхгүй байх, эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх, эрүүгийн хууль туйлын тодорхой байх гэсэн агуулгыг илэрхийлдэг. Эрүүгийн хууль, түүний хэм хэмжээ, нэр томьёо нь туйлын тодорхой байдлаар хуульчлагдсан байх ёстой. Ингэснээр эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх асуудал багасаж, эрүүгийн хууль дахь хүний эрхийн баталгаа хангагдах механизм бүрдэнэ. Тиймээс эрүүгийн хуульд гэмт болгон заасан үйлдлийн урьдчилсан нөхцөл буюу гэмт хэргийн хэм хэмжээний бүрэлдүүн туйлын тодорхой байх шалгуурт нийцэж буй эсэхийг судлах нь хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хангах, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх, хүний эрх эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх давуу талтай юм. Энэхүү өгүүллээр дамжуулан тусгай ангийн зарим хэм хэмжээний бүрэлдүүнийг шинжилсний үндсэн дээр 2015 оны Эрүүгийн хуульд “туйлын тодорхой байх” зарчим хэрэгжиж буй байдлыг тодорхойлон, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, түүнийг засаж залруулах, даван туулах арга замыг эрэлхийлэхийг зорилоо.

## **II. Эрүүгийн хууль туйлын тодорхой байх нь**

Хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийн цогц буюу гэмт хэргийн бүрэлдүүн хэмээх ухагдахуун нь гэмт хэрэг буюу хууль бус хэмээн үзэх үйлийн хууль зүйн шинжийг хэм хэмжээнд хэлбэржүүлсэн байдал юм.<sup>1</sup> Германы эрдэмтэн Белинг эрүүгийн хуулийн хэм хэмжээн дэх урьдчилсан нөхцөлийн цогц нь тодорхой үйлийг хууль бус хэмээн илэрхийлэх мөн чанар, төрлийг илтгэх дотоод шинжүүдийг агуулна гэж тодорхойлжээ. Тэрээр мөн хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийн цогцыг хууль ёсны зарчимтай холбон авч үзэж, хууль ёсны зарчмын илрэл бол гэмт хэргийн бүрэлдүүн буюу хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийн цогц хэмээгээд түүний баталгааг хэм хэмжээний цогц үүсгэнэ гэх санааг дэвшүүлсэн. Белингийн дэвшүүлсэн санааг илүү дэлгэрэнгүй тайлбарлавал, эрүүгийн хуулийн хэм хэмжээний урьдчилсан нөхцөл, түүний бүтээцэд эрүүгийн хуулиар хориглох үйлийн хууль зүйн шинжийг хоёрдмол утгагүй туйлын тодорхой хуульчилж өгсөн байх учиртай. Ингэснээр эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх асуудал үгүй болох юм.<sup>2</sup> Эрүүгийн хуулийн агуулга тодорхойгүй, хоёрдмол утгатай бөгөөд энгийн нөхцөлд тухайн

---

<sup>1</sup> Uwe, M. (2017). Grundkurs Strafrecht.4. Aufl., Verlag C.H. Beck München. 2017. S. 65.

<sup>2</sup> Золбоо Т. Гэмт хэргийн бүрэлдүүн. Уб., 2023./ Гэмт хэргийн бүрэлдүүн эрүүгийн эрх зүйн суурь асуудал болох нь. /Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон судалгааны ажил/. Уб., 2022. 10 дахь тал.

агуулгыг ойлгох боломжгүй тохиолдолд ард иргэд хууль ёсны болоод хууль бус үйлдлийг урьдчилан таамаглах боломж үгүй болж, хууль сахиулах байгууллагууд хууль тогтоомжийг дур зоргоороо хэрэглэх эрсдэлтэй юм.<sup>3</sup> Үүнийг “эрүүгийн хууль туйлын тодорхой байх” зарчим гэж нэрлэдэг. Харин “эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх” зарчим ёсоор шинээр батлагдсан эрүүгийн хууль түүнээс өмнө үйлдэгдсэн үйлдэлд үйлчлэх учиргүй. Белинг дээрх бүгдийг нийлүүлэн хуулийн хэм хэмжээний баталгаа буюу үйл ажиллагааны баталгаа хэмээн нэрлэжээ.

Эндээс үзвэл “туйлын тодорхой байх” зарчим нь гэмт хэрэг, түүнд оногдуулах ялын байдлыг тодорхой байлгах агуулгыг илэрхийлж, улмаар эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх үндсийг бүрдүүлдэг тул, “туйлын тодорхой байх” зарчмын ач холбогдлыг хууль ёсны зарчим бодитоор хэрэгжих гол үндэс, хүний эрхийг хамгаалах баталгаа мөн хэмээн тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл аливаа гэмт үйлийн хэм хэмжээнд хэлбэршсэн шинж нь туйлын тодорхой байснаар хууль ёсны зарчмын бусад дэд зарчим хэрэгжих нөхцөл бүрдэж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлнэ. “Туйлын тодорхой байх” зарчим нь ямар үйл гэмт хэрэг болох, түүний урьдчилсан нөхцөл байдлыг хоёрдмол утгагүй заахаас гадна, гэмт хэрэгт хүлээлгэх ялын төрөл, түүний хугацааны дээд, доод хэмжээг тодорхой заана гэсэн утгыг агуулдаг байна.

### **III. Монгол улсын Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээний тодорхой бус, зөрчилдөөнтэй байдал**

Эрүүгийн хуульд заасан тодорхой үйлийн хууль зүйн шинжүүдийг тодорхойлсон хэм хэмжээний цогц буюу гэмт хэргийн бүрэлдүүн нь үйлийн бодит байдлыг илэрхийлэх объектив талын шинж, түүний дотоод нөхцөл байдлыг илэрхийлэх субъектив талын шинжээс бүрдэнэ.<sup>4</sup> Тиймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим хэм хэмжээний объектив, субъектив талын шинж, тэдгээрийг тайлбарлан хэрэглэж буй практик нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх замаар Эрүүгийн хуулийн хэм хэмжээний тодорхой бус байдал, практикт үүсэж буй сөрөг үр дагаврыг илрүүлэе.

#### **A. §12.1 Хүчиндэх, §12.2 Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэм хэмжээний бүрэлдүүн**

2015 оны Эрүүгийн хуульд Хүчиндэх болон Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэм хэмжээний бүрэлдүүний шинжийг хэрхэн томъёолсныг авч үзье.

<sup>3</sup> 정영일. 신 형법총론. 2018. 51면.

<sup>4</sup> Золбоо Т. Гэмт хэргийн бүтээц. Уб., 2023. 47 дахь тал.

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний хүсэл зоригоос гадуур хурьцал үйлдэх, энэ зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх, заналхийлэх буюу биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж үйлдсэн байдаг.<sup>5</sup> Биений хүчээр буюу сэтгэхүйн хүч, заналхийллээр сүрдүүлэн халдаж, хохирогчийн зөвшөөрөлгүй хурьцал үйлдэх явдал юм.<sup>6</sup>

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэг бол хохирогчийг тохуурхан доромжилж, хүн төрөлхтний биологийн заяагдмал ёсноос гадуур<sup>7</sup> эр, эмийн ёсоор хурьцал үйлдэх хүсэлгүй, гагцхүү садар самуун байдлаар хурьцал үйлдэхийг хэлнэ.<sup>8</sup>

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд Хүчиндэх гэмт хэргийн бүрэлдүүнийг “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, ... хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол” гэж, 12.2 дугаар зүйлд Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн бүрэлдүүнийг “Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, ... бэлгийн шинжтэй тодорхой үйлдэл хийсэн, эсхүл хохирогчоор хийлгэж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол” гэж тус тус томъёолжээ.

Эндээс үзэхэд Хүчиндэх гэмт хэргийн үйлдэл<sup>9</sup> нь бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл байх бол, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн үйлдэл нь субъект бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бэлгийн шинжтэй үйлдэл байна. Тус хоёр хэм хэмжээний гол ялгаа нь “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан” гэх шинжээр илэрч байна. Гэвч бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан гэх үйлдлийн гадаад ертөнцөд илрэх шинж буюу үйлдлийн арга, мөн тухайн үйлдлийн ёс бус шинжийг илэрхийлэх урьдчилсан нөхцөл тодорхой бус байна. Мөн бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл, бэлгийн шинжтэй тодорхой үйлдэл гэх хоёр ойлголт нь ижил утга агуулгыг илэрхийлэх эсэх нь тодорхой бус байгаагийн дээр, 12.1 дүгээр зүйлийн аутентик тайлбарт “Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэдгийг “хохирогчийн биений аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” хэмээн тайлбарласан зэрэг нь тус хоёр гэмт хэргийг ялган зүйлчлэх тал дээр маргаантай асуудлыг үүсгэж байна.

<sup>5</sup> Монгол Улсын дээд шүүх., Ханнс-Зайделийн сан. Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 331 дэх тал. 333 дахь тал.

<sup>6</sup> Совд Г. 190

<sup>7</sup> Совд Г. 192

<sup>8</sup> Монгол Улсын дээд шүүх., Ханнс-Зайделийн сан. Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Уб., 2010. 331 дэх тал.

<sup>9</sup> Гэмт хэргийн бүрэлдүүний объектив талын шинж

Өөрөөр хэлбэл “хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан” үйлдэл нь дээрх хоёр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг нэгэн зэрэг хангаж байгаа юм. Үүнээс үүдэн эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл үүссэн байна. Тухайлбал,

Шүүхийн шийдвэр 1. Шүүгдэгч Ч.Ө нь хохирогч Б.Н-ийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, бэлэг эрхтнийг нь хэлээрээ долоох, үнсэх, сорох, хуруугаа хийх зэргээр бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн нь нотлогдсон ба шүүгдэгч Ч.Ө-г Эрүүгийн хуулийн §12.1.2.1-т заасан арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.<sup>10</sup>

Шүүхийн шийдвэр 2. Шүүгдэгч Б.\*\*\*\*\* нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 8 настай, эрэгтэй Л.\*\*\*\*\*-ийг унтаж байхад нь бэлэг эрхтнээ ам руу нь оруулж, бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн нь нотлогдсон ба шүүх Б.\*\*\*\*\* -г Эрүүгийн хуулийн тусгай ангийн §12.1.4-т заасан Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.<sup>11</sup>

Шүүхийн шийдвэр 3. Шүүгдэгч Г.Т нь насанд хүрээгүй хохирогч О.М-ийн хүсэл зоригийнх нь эсрэг, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан аманд нь бэлэг эрхтнээ оруулсан ба прокурорын газраас Г.Т-г Эрүүгийн хуулийн 12.1.4-т заасан бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж, бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хэмээн яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн. Шүүх Г.Т-г өөрийн бэлгийн дур хүслээ бэлгийн харьцааны замаар бус садар самуун байдлаар хангасан байх тул түүний үйлдэл Хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хангаагүй байна гэж дүгнэж, Эрүүгийн хуулийн §12.2.3-т заасан Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.<sup>12</sup>

Шүүхийн шийдвэр 4. Шүүгдэгч Д.О хохирогч Н.С-ийн үснээс нь зулгаан, жалга руу чирч оруулан улмаар хүчээр заналхийлж, ам, чих, хөл рүү гараараа цохиж, хөлөөрөө өшиглөх зэргээр хүч хэрэглэн зодож, бэлэг эрхтнээ ам руу нь хийсэн ба шүүгдэгч Д.О-г Эрүүгийн

<sup>10</sup> Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол., 2021.08.26. Дугаар 2021/ШЦТ/183.

<sup>11</sup> Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2024.11.04. Дугаар 2024/ШЦТ/770

<sup>12</sup> Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дах сум дундын шүүхийн шийтгэх тогтоол. 2021.01.19. Дугаар 2020/ШЦТ/06.

хуулийн §12.2.1-т заасан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.<sup>13</sup>

Дээрх шүүхийн шийтгэх тогтоолуудад дүн шинжилгээ хийж үзвэл “хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан” гэх үйлдлийг бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хэмээн тодорхойлж, зарим тохиолдолд Хүчиндэх гэмт хэргээр, зарим тохиолдолд Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргээр зүйлчилсэн байна.

Өөрөөр хэлбэл практикт ижил үйлдлийг ялгамжтай зүйлчилж, хуулийг нэг мөр хэрэглэхгүй байна хэмээн дүгнэж болохоор байна. Энэ нь эрүүгийн хуулийн хэм хэмжээ зөрчилдөөнтэй, тодорхой бус хуульчлагдсаны сөрөг үр дагавар юм.

### **Б. §20.16 Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэм хэмжээний бүрэлдүүн**

Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйлд заасан “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах” гэмт хэргийн үндсэн бүрэлдүүний шинжийг “Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэж, эсхүл эд хөрөнгө устгаж, гэмтээж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний халдашгүй, чөлөөтэй байх, эд хөрөнгө өмчлөх эрхийг зөрчиж, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан бол” гэж, хүндрүүлэх бүрэлдүүний шинжийг “бусдын эрүүл мэндэд хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж” гэж заажээ.

Тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдүүнд “бусдын эрүүл мэндэд хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж” гэж заасан нь бусдын эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, амь нас хохирсон бодит хор уршиг учирсан байхыг шаардах уу? гэсэн эргэлзээтэй байдлыг бий болгож байна. Үүнийг бодит хор уршиг учирсан нөхцөл байдлаас ялгаж, хүнд хохирол учрах, хүний амь нас хохирч болох байсан тодорхой нөхцөл байдал<sup>14</sup> бий болсон гэж ойлгох нь зүйн хэрэг юм. Гэвч хүнд хохирол учруулж болох байсан нөхцөл, амь нас хохирч болох байсан нөхцөл байдлыг илэрхийлэх шинжийг тодорхой зааж хуульчлаагүй ба хэрэв үндсэн бүрэлдүүнд

<sup>13</sup> Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол., 2021.05.24. Дугаар 2021/ШЦТ/343. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан.

<sup>14</sup> Мөнх-Очир Т. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт. /Магистрын зэрэг горилсон бүтээл/. Уб., 2021. МУИС, Цахим номын сан. <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=124899>

заасан гэмт үйлдлийн улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр хохирол учирсан бол 20.16.2.4-т заасан “хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэсэн” гэдэгт тооцогдох эсэх нь эргэлзээтэй, “хүнд хохирол учрах, амь нас хохирох” гэх нөхцөл нь “хөнгөн, хүндэвтэр хохирол учрах” нөхцөлөөс хэрхэн ялгагдах зэрэг нь тодорхой бус байна.

Энэ талаар Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарын эрдэмтэд “бусдын эрүүл мэндэд хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж гэж заасан хүндрүүлэх шинж хууль хэрэглэгчийн үзэмжийн асуудал болж хувирахыг үгүйсгэхийн аргагүй юм.”<sup>15</sup> хэмээн тэмдэглэжээ.

Тус хэм хэмжээг практикт хэрхэн хэрэглэж буй байдлыг судалж үзье.

Шүүхийн шийдвэр 1. Шүүгдэгч Т.Н, Х.Д нар “Будда Виста” хотхоны ресторанд эмх замбараагүй байдал бий болгож, хохирогч Д.Ц-г “биеэ зөв авч явсангүй” гэж маргалдан нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, хүч хэрэглэн олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан бөгөөд хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан. Прокурорын газраас шүүгдэгч Т.Н, Х.Д нарыг Эрүүгийн хуулийн §11.1.2.1-т заасан гэмт хэрэгт холбогдсон гэж яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн §20.16.2.4 болгон өөрчлөн, Т.Н, Х.Д нарын холбогдсон хэрэг нь 20.16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т заасан гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан байна гэж тайлбарлажээ.<sup>16</sup> Улмаар давж заалдах шатны шүүх<sup>17</sup> шүүгдэгч Х.Д-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Т.Н-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ба хяналтын шатны шүүх<sup>18</sup> давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Шүүхийн шийдвэр 2. Г.Ө, М.Т, Ч.Б нар нь “Х” /Икс/ нэртэй караокед нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэж, Г.Ө нь Б.О-г шатны уруу тийрэн унагаж, улмаар Б.О-ийн эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан. Прокурорын газраас Г.Ө-г Эрүүгийн хуулийн §20.16.2.4-т заасан гэмт хэрэгт, М.Т, Ч.Б нарыг Эрүүгийн хуулийн §20.16.1-т заасан гэмт хэрэгт холбогдсон гэж

<sup>15</sup> Нарангэрэл С., Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. Уб., 2019 он. 218 дахь тал.

<sup>16</sup> Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2020.01.17. Дугаар 110.

<sup>17</sup> Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2020.04.30. Дугаар 532.

<sup>18</sup> Улсын дээд шүүхийн тогтоол. 2020.07.17. Дугаар 419.

яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн ба анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр “Эрүүгийн хуулийн §20.16.2.4-т хүний эрүүл мэндэд хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж үйлдсэн гэх тус гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, шууд чиглэсэн үйлдэл хоёрыг ялган зааглах асуудал үүссэн. Гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнийг хангасан үйлдлүүд, тэдгээрийн үр дагавар нь тухайн нөхцөл байдалд хүргэсэн буюу бүлэглэсэн үйлдлүүдийн нийлмэл, нэгдмэл, нэг ба хэд хэдэн удаагийн шинж байдал давхар тогтоогдсон байхыг шаардахаар байна” хэмээн тайлбарлаж, хэргийг прокурорт буцаасан. Улмаар прокурор нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийж Г.Ө-г Эрүүгийн хуулийн §11.1.1-т заасан хэрэгт холбогдсон, М.Т, Ч.Б нарыг Эрүүгийн хуулийн §20.16.1-т заасан хэрэгт холбогдсон гэж яллах дүгнэлт үйлдэн ирүүлж хэргийг дахин анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Анхан шатны шүүх<sup>19</sup>, давж заалдах шатны шүүх<sup>20</sup>, хяналтын шатны шүүх<sup>21</sup> тус хэргийн зүйлчлэлийг зөвтгөж, шүүгдэгч нарыг гэм буруутайд тооцжээ.

Дээрх шүүхийн шийтгэх тогтоолуудаас үзэхэд “бусдын эрүүл мэндэд хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж” гэж заасныг нэгдмэл бус байдлаар тайлбарлан хэрэглэж байгаа нь мөн л эрүүгийн хуулийн хэм хэмжээ тодорхой бус хуульчлагдсаны сөрөг үр дагавар юм.

### **В. §18.6 Мөнгө угаах хэм хэмжээний бүрэлдүүн**

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Мөнгө угаах гэмт хэргийн хэм хэмжээний бүрэлдүүнийг “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол” гэж хуульчилсан ба объектив талын үндсэн шинжид бие даасан гурван үйлдлийг “;” буюу “цэгтэй таслал”-аар тусгаарлаж, хуульчилсан байна.

Мөнгө угаах гэмт хэргийн субъектив талын нэмэгдэл шинж болох зорилгыг “хууль, бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор” гэж хуульчилсан байна.

<sup>19</sup> Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2018.01.19. Дугаар. 67.

<sup>20</sup> Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2018.04.12. Дугаар 359.

<sup>21</sup> Улсын дээд шүүхийн тогтоол. 2018.06.27. Дугаар 316.

Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт замаар бусад этгээдийн зориуд олсон мөнгө буюу бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах ба захиран зарцуулахад хууль ёсны болгон хувиргах зорилгоор санхүүгийн ажиллавар ба хэлцэл үйлдэх явдал юм.<sup>22</sup> Өөрөөр хэлбэл Мөнгө угаах гэмт хэрэг нь “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг хууль ёсны болгон хувиргах зорилготой үйлдэгддэг” мөн чанартай. Гэвч дээрх хэм хэмжээний субъектив талын шинж болох зорилго нь зөвхөн “... өөрчилсөн, шилжүүлсэн” гэх үйлдэлд хамаарах уу “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; ..... ; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол” гэх үйлдлүүдэд бүгдэд нь хамаарах уу гэдгийг тодорхойгүй байдлаар хуульчилсан байна. Гэмт хэргийн бүрэлдүүн нь объектив болон субъектив талын шинжээс бүрдэнэ гэх үзлийг үндэслэгч, Германы эрүүгийн эрх зүй, эрх зүйн философи судлаач Уэлзелийн тодорхойлсноор хүн зорилгодоо хүрэхийн тулд үйлдлийн гурван үе шатыг хэрэгжүүлэх ба энэ нь зорилгоо тодорхойлох, зорилгодоо хүрэх арга хэрэгслийг тодорхойлох, хүслээ гүйцэлдүүлэх буюу үйлдэл хийх явдал юм. Аливаа үйл бол хүний хүсэл зоригийн илэрхийлэл, энэ хоёр бол салшгүй шалтгаант холбоотой байна хэмээн үзэж хүсэх элемент болон зорилгыг хэм хэмжээний бүрэлдүүнд багтаасан. Тийм учраас онолын үүднээс авч үзвэл хэм хэмжээний гурван бие даасан үйлдэл нь гурвуулаа нэг зорилгын үүднээс хийгдэх ёстой юм. Өөрөөр хэлбэл нэг хэм хэмжээнд яг нэг л зорилго заавал байна гэсэн үг.

Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолуудыг судалж үзэхэд зарим шүүхийн шийтгэх тогтоолд “хууль, бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах” зорилгыг тус гэмт хэргийн бүрэлдүүнд заасан бүх үйлдэлд хамаарна гэх байдлаар тайлбарласан<sup>23</sup> байгаа бол, зарим шүүхийн шийтгэх тогтоолд дээрх зорилго нь зөвхөн “өөрчилсөн, шилжүүлсэн” үйлдэлд л хамаарна хэмээн тайлбарлаж, хэргийг шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл хэм хэмжээ тодорхой бус хуульчлагдсанаас үүдэн хуулийг нэгдмэл бус байдлаар хэрэглэж байна.

Хэрэв гэмт хэргийн хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас

<sup>22</sup> Нарангэрэл С., Эрдэнэбулган Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. Уб., 2019 он. 221 дахь тал. Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2011 он. 287 дахь тал.

<sup>23</sup> Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2023.04.19. Дугаар 2023/ШЦТ/570., Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2021.11.04. Дугаар 2021/ШЦТ/746.

зайлсхийхэд туслах зорилго нь Мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдүүний бүх үйлдлийн шинжид хамаарна гэж тайлбарлавал Мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсон дийлэнх шүүхийн шийдвэрүүд нь үндэслэлгүй буюу хуулийг буруу хэрэглэсэн болох юм.

Дээр дурдсан Эрүүгийн хууль дах зарим гэмт хэргийн бүрэлдүүнийг тодорхой бус хуульчилснаас үүдэн, хэм хэмжээг нэгдмэл бус байдлаар тайлбарлан хэрэглэж байна. Энэ нь “Эрүүгийн хуулиар дамжин хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх” сэргийлэх, түүнийг хамгаалах баталгаа үгүй болсны илрэл юм.

#### **IV. Монгол улсын Эрүүгийн хуулийн зарим нэр томьёоны тодорхой бус байдал**

Хууль зүйн нэр томьёо нь эрх зүйн зохицуулалтын зарчим, хэм хэмжээ, арга хэлбэрийг тодорхойлоход чиглэгдсэн бүхий л ойлголт ухагдахууныг өөртөө багтаасан байдаг<sup>24</sup>. Хууль зүйн шинжлэх ухаанд текстийг үгийн шууд утгаар нь тодотгож тайлбарлах нийтлэг арга хэрэглэгддэг<sup>25</sup> тул нэр томьёо нь аливаа агуулгыг хангалттай илэрхийлж чадахуйц байдлаар хуульд хэлбэржсэн байх шаардлагатай юм. Иймд Эрүүгийн хуулийн хэм хэмжээг бүрдүүлж буй зарим нэр томьёонд дүн шинжилгээ хийж үзье.

##### **А. Эрүүгийн хууль дах хүч оруулсан нэр томьёо**

Эрүүгийн хуульд “илт” хэмээх хүч оруулсан нэр томьёо нь нийт 10 удаа бичигдсэн байна. Тухайлбал, 2 хэм хэмжээнд “...илт худал...”, 2 хэм хэмжээнд “...хэр хэмжээнд илт тохироогүй...”, 3 хэм хэмжээнд “...илт хууль бус”, 1 хэм хэмжээнд “...илт хохиролтой...”, 1 хэм хэмжээнд “...илт хэтрүүлж...”, 1 хэм хэмжээнд “...эрхэд илт халдахаар...” гэх байдлаар томьёолж, гэмт хэргийн шинжийг хүч оруулсан нэр томьёогоор илэрхийлжээ.

Хэл зүйн үүднээс авч үзвэл илт хэмээх нэр томьёо нь илэрхий, тодорхой, баримттай гэсэн утгыг илэрхийлнэ.<sup>26</sup> Гэтэл тус нэр томьёо нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээнд тусгагдаж, ямар утгыг илэрхийлж байгаа нь тодорхой бус байна.

Илт худал гэх нэр томьёог жишээ авч тайлбарлавал: Эрүүгийн хуулийн тусгай ангийн нийт 14 хэм хэмжээнд “худал” хэмээх үг бичигдсэн байх бөгөөд тэдгээрээс 2 хэм хэмжээнд нь “илт худал” хэмээн зааж, илт хэмээх нэр томьёогоор хүч оруулсан байна.

<sup>24</sup> Баярсайхан Д. Эрх зүйн онол. Уб., 2020.

<sup>25</sup> Ханнс-Зайделийн сан. Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Эрүүгийн эрх зүй. Уб., 2018. 33 дахь тал.

<sup>26</sup> Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 2021 он. 447 дахь тал.

Эрүүгийн хууль дах илт худал хэмээх ойлголт нь худал гэдэг ойлголттой ижил үү? эсвэл түүнээс өөр утгыг илэрхийлэх үү? Хэрэв өөр утгыг илэрхийлнэ гэж үзвэл илт худал буюу худал гэдэг нь илт буюу илэрхий, тодорхой, баримттай гэдэг нь ямар шинжээр илрэх вэ? гэдэг нь тодорхой бус юм.

Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 7 хэм хэмжээнд “харгис” гэх нэр томьёо бичигдсэн ба тэдгээрийн 4 хэм хэмжээнд “харгис хэрцгий”, 2 хэм хэмжээнд “онц харгис хэрцгий” хэмээн тусгаж, хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөлд хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх шаардлагыг тавьдаг. Гэвч энэхүү шаардлагыг зөрчин 2015 оны Эрүүгийн хуулийн төслийг боловсруулахдаа хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байгаа нь хуулийг тайлбарлахад хүндрэлтэй, зөрчилдөөнтэй байдлыг бий болгож байгаа юм.

### **Б. Эрүүгийн хууль дахь “бусад байдлаар, бусад хэлбэрээр” гэх нэр томьёоны тухайд**

Бусад байдал, бусад нөхцөл байдал” гэх нэр томьёо нь “бусад байдлаар эрхшээлд орсон, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлд байгаа, бусад хүнд байдлыг далимдуулж” гэх зэргээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээнд хуульчлагдсан байна. Тухайлбал, “бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлд байгаа” гэх байдлаар ерөнхий ангийн 1 хэм хэмжээ, тусгай ангийн 3 хэм хэмжээнд, “бусад хүнд байдал” гэх байдлаар тусгай ангийн 4 хэм хэмжээнд тусгагджээ.

Хууль тогтоогч халдлагад өртөгч этгээд бусдын эрхшээлд байгаа нөхцөл байдлыг эд хөрөнгө, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, албан тушаалын улмаас эрхшээлд байгаа гэж тодруулан заасан хэдий ч, хамгийн сүүлд нь эрхшээлд байгаа бусад нөхцөл байдал гэж ерөнхийлөн заасан ба үүнд ямар нөхцөл байдлыг хамааруулж ойлгох нь тодорхой бус байна.

Мөн халдлагад өртөгч этгээдийн хувийн байдлыг тодорхойлохдоо хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал хэмээн заасан бөгөөд хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин зэргээс бусад хүнд байдлыг ямар шинжээр тодорхойлж, ямар нөхцөл байдлыг хамааруулж ойлгох нь тодорхой бус байна. Тодорхой бус байдлаар заасан “бусад байдлаар, бусад хэлбэрээр” гэх ерөнхий томьёолол дор эрүүгийн хуулийн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх, гэмт бус үйлдлийг гэмт хэрэгт тооцох нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй юм.

## **V. Тодорхой бус байгаагийн шалтгаан, түүнийг даван туулах арга зам**

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээ тодорхой бус хуульчлагдаж байгаа нь манай улсад эрүүгийн хуулийн хэм хэмжээг гэмт хэргийн бүрэлдүүн буюу хэм хэмжээний цогцын бүтээцийн дагуу бүтээх нэгдсэн арга зүй дутмаг байгааг илтгэж буй хэрэг юм. Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүх хэм хэмжээг нэгдсэн арга зүйн дагуу бүтээж, хуульд хэлбэржүүлэх шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэгт тооцогдох үйлийн хууль зүйн шинжийг хэм хэмжээний онолд суурилан нэгдсэн арга зүйн дагуу бүтээж, хуульд хэлбэржүүлэх шаардлагатай.

Хууль тогтоогч тодорхой үйлийг гэмт болгон хуульд хэлбэршүүлэхдээ гэмт хэргийн бүрэлдүүн буюу хэм хэмжээний цогц, түүний онолын үндэслэлийг баримтлаагүй юм хэмээн үзэж болохоор байна. Жишээ нь, өмнөх хэсэгт дурдсанчлан Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан “...хүнд хохирол учрах, амь нас хохирох нөхцөл байдалд хүргэж” гэж заасан нь материаллаг хор уршиг шаардах уу? Үгүй юу? гэдэг нь эргэлзээтэй ба хэрэв хууль тогтоогч тус хэм хэмжээг гэмт хэргийн бүрэлдүүний системийн дагуу томъёолсон бол материаллаг хор уршиг шаардах эсэхийг нь тодорхой заах боломжтой байсан.


Гэмт хэрэг бол хүний тодорхой үйл юм.<sup>27</sup> Эрүүгийн хуульд заасан тодорхой үйлийн объектив, субъектив шинжүүдийг тодорхойлсон хэм хэмжээний цогц нь гэмт хэргийн бүрэлдүүн байна<sup>28</sup>. Өөрөөр хэлбэл тодорхой үйл байх бөгөөд тухайн үйлийн илрэх хэлбэр буюу үйлдэл, түүний улмаас бий болох хор уршиг, үйлдэл, хор уршиг хоорондын шалтгаант холбоо зэрэг нь объектив талын шинжид<sup>29</sup> хамаарах ба тухайн үйлийг үйлдсэн хүсэл зориг, санаа, зорилго, сэдэлт нь субъектив талын шинж байна.<sup>30</sup> Гэмт хэрэгт тооцогдох үйлийг илэрхийлж буй хэм хэмжээ нь энэхүү системийн дагуу томъёологдож, хуульд хэлбэржсэн байх ёстой. . Хуульд бүх нөхцөл байдлыг бүрэн хамарч хуульчлах боломж байдаггүй учир түүнийг хэм хэмжээний цогцын ухагдахуунд хураангуйлан томъёолно.

<sup>27</sup> Золбоо Т. Гэмт хэргийн бүрэлдүүн. Уб., 2023 он./Золбоо Т. Гэмт хэргийн бүрэлдүүн эрүүгийн эрх зүйн суурь асуудал болох нь. Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон судалгааны ажил. Уб., 2022. 2-7 дахь тал.

<sup>28</sup> Мөн тэнд.

<sup>29</sup> Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги. Уб., 1996. 113-114 дэх тал., Золбоо Т. Гэмт хэргийн бүтээц. Уб., 2023. 85-87 дахь тал.

<sup>30</sup> Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги. Уб., 1996. 156 дахь тал., Золбоо Т. Гэмт хэргийн бүтээц. Уб., 2023. 96-97 дахь тал.



## VI. Дүгнэлт, санал

Энэхүү өгүүллээр 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээ, нэр томъёонд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг тайлбарлан хэрэглэж буй шүүхийн практикийг судлан дараах үр дүнд хүрч, санал дэвшүүллээ.

Нэг. 2015 оны Эрүүгийн хууль нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагад нийцэхгүй байгааг эрүүгийн хуульд бичигдсэн хүч оруулсан нэр томъёо болон тусгай ангийн хэм хэмжээнд заасан тодорхойгүй нэр томъёоноос харж болох юм.

Хоёр. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, Мөнгө угаах, Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах зэрэг гэмт хэргийн бүрэлдүүний шинж буюу хуульд томъёолсон байдал тодорхой бус, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргийн бүрэлдүүн өөр хоорондоо ижил төстэй байдлаар хуульчлагдсан байгаагаас үүдэн практикт хуулийг нэгдмэл бус байдлаар тайлбарлан хэрэглэж байна. Эдгээр нь тодорхой үйлийг Эрүүгийн хуульд гэмт болгон заахдаа хэт ерөнхий, тодорхой бус байдлаар хуульчилж, хэм хэмжээ хоорондын уялдаа холбоог алдагдуулсны сөрөг үр дагавар бөгөөд мөн манай улсад Эрүүгийн хуулийн хэм хэмжээг нэгдсэн арга зүйн дагуу бүтээж, нэгдсэн арга зүйн дагуу тайлбарлах нөхцөл бүрдээгүй байгаагийн илрэл юм. Үүний үр дагаварт эрх зүйт төрийн үндсэн баталгаа болсон хууль ёсны зарчим зөрчигдөж Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөг төрийн дарамт, хүчирхийллээс хамгаалах хууль ёсны баталгаа үгүй болсон байна. Иймд өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийг шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой байдлаар системчлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарчээ.

Гурав. Хэм хэмжээний онолд тулгуурлан тусгай ангийн хэм хэмжээг томъёолох нэгдсэн арга зүйг бий болгох шаардлагатай

байна. Хуулийн төслийг боловсруулах явцад эхлээд тухайн хэм хэмжээний диспозицийн бүтээцийг хэм хэмжээний онолд суурилан схемчлэн бүтээж, дараа нь түүний дагуу хуульд хэлбэржих байдлаар нь томьёолох арга зүйг нэвтрүүлэх шаардлагатай байна. Ингэснээр эрүүгийн хууль тодорхой хуульчлагдаж, тусгай анги дах ойролцоо төрлийн хэм хэмжээнүүдийг ялгахад хялбар болохын сацуу, хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх нэгдмэл арга зүй бий болно. Жишээ болгож энд “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэргийн бүрэлдүүн буюу хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийг томьёоллоо.

1. Гэмт хэргийн бүрэлдүүний объектив, субъектив талын шинжийг дараах байдлаар схемчилнэ:

*Хүснэгт 1.*

<b>Объектив тал</b>	<b>Үйлдэл (арга, илрэх шинж):</b>	хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг - хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, - эсхүл хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж: хурьцал үйлдэхгүйгээр тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан үйлдэл,
	<b>Хор уршиг:</b>	хохирогчийн бэлгийн эрх чөлөөнд хор уршиг учрах хэдий ч, үйлдэл хийснээр гэмт хэрэг төгсөх тул материаллаг хор уршиг учирсан байхыг шаардахгүй,
	<b>Шалтгаант холбоо:</b>	хэлбэрийн бүрэлдүүнтэй буюу материаллаг хор уршиг учирсан байхыг шаардахгүй тул шалтгаант холбоог авч үзэхгүй,
<b>Субъектив тал</b>	<b>Санаатай</b>	мэдэх элемент (+)
		хүсэх элемент (+)
	<b>Зорилго</b>	хурьцал үйлдэхгүйгээр бэлгийн дур хүслээ хангах зорилготой

2. Дээрх схемийн дагуу хуульд хэлбэржих байдлыг томьёолно:

“Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулж хурьцал үйлдэхгүйгээр тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол ...” гэсэн байдлаар хэм хэмжээний урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж болохоор байна.

**[Ном зүй]**

- Баярсайхан Д. Эрх зүйн онол. Уб., 2020.
- Гантулга С., Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: Тусгай анги. Уб., 2020.
- Гантөмөр Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. Уб., 2011.
- Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургаал/. Уб., 2009.
- Золбоо Т. Гэмт хэргийн бүтээц. Уб., 2023.
- Золбоо Т. Гэмт хэргийн бүрэлдүүн. Уб., 2023./ Гэмт хэргийн бүрэлдүүн эрүүгийн эрх зүйн суурь асуудал болох нь /Хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл/. Уб., 2022
- Золбоо Т. Сургалтын Эрүүгийн хууль. Уб., 2023. 110 дахь тал.
- Мөнх-очир Т. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт. /Магистрын зэрэг горилсон бүтээл/. Уб., 2021.
- Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги. Уб., 1996.
- Нарангэрэл С., Эрдэнэбулган Ж. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж. Уб., 2019.
- Нарангэрэл С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Уб., 2021.
- Ханнс-Зайделийн сан. Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй: Эрүүгийн эрх зүй. Уб., 2018.
- Хилгендорф Э., Чанцалдулам Д. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Уб., 2015.
- Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 2021.
- Uwe, M. (2017). Grundkurs Strafrecht.4. Aufl., Verlag C.H. Beck München. 2017
- 정영일. 신 형법총론. 2018.
- Үндсэн Хууль. 1992.
- Хууль тогтоомжийн тухай хууль. 2015.
- Эрүүгийн хууль. 2015.
- Архангай аймаг дах сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол., 2021.08.26. Дугаар 2021/ШЦТ/183.
- Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол. 2024.07.02. Дугаар 2024/ШЦТ/66.
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2018.04.12. Дугаар 359.
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2020.04.30. Дугаар 532.
- Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн

шийтгэх тогтоол. 2018.01.19. Дугаар. 67.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2023.07.31. Дугаар 2023/ШЦТ/752.

Улсын дээд шүүхийн тогтоол. 2018.06.27. Дугаар 316

Улсын дээд шүүхийн тогтоол. 2020.04.17. Дугаар 202.

Улсын дээд шүүхийн тогтоол. 2020.07.17. Дугаар 419.

Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2020.01.17. Дугаар 110.

Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2024.11.04. Дугаар 2024/ШЦТ/770

Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2024.01.31. Дугаар 2024/ШЦТ/40.

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн шийтгэх тогтоол. 2021.01.19. Дугаар 2020/ШЦТ/06.

**[Abstract]**

**The Principle of Certainty and Criminal Code of Mongolia**

**Togoo Zolboo**

*Doctor of Laws (Ph.D),*

*Associate professor of Public Law Department*

*School of Law, National University of Mongolia*

*Ulaanbaatar, Mongolia*

**Bolormaa Azzaya**

*4<sup>th</sup> course student*

*School of Law, National University of Mongolia*

*Ulaanbaatar, Mongolia*

When making a legal syllogism comparing the norms of a special class of the Criminal code of Mongolia with a specific case or real action, there are various problems, such as the lack of understanding of the formulation of some types of crimes. It does not correspond to The Legal principle that is the main guarantee of a democratic state, so this article purposes to identify some conflicting problems of the Criminal Code and seek ways to correct and overcome them. Based on “The Principle of Legality” and “the elements of crime that make up the complex of norms”, some norms of the Criminal code and the terms that make up it were analyzed, and as a result, it was determined that the elements of some crimes in special part was legislated in a vague manner in the Criminal code and the coordination between the norms was disturbed. As a result, the “Methodology for creating and developing quantitative measures” is proposed to improve the process of drafting the Criminal Code.

**[Keywords]**

Criminal law, elements of crime, norm, term, uncertainty in Criminal code.